

“Эрдэнэс-Тавантолгой”ХК-ийн  
Гүйцэтгэх захирлын 2018 оны  
10 дугаар сарын 23 ны өдрийн 10374  
дугаар тушаалын 8 дугаар  
хавсралт

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СОГТУУРУУЛАХ УНДАА, МАНСУУРУУЛАХ БОДИС ХОРИГЛОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Эрдэнэс-Тавантолгой” ХК /цаашид “ЭТТ” ХК гэх/-д сахилга дэг журмыг сайжруулах зорилгоор ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журмыг “ЭТТ” ХК-ийн ажилтан, зочин, гэрээт болон туслан гүйцэтгэх компанийн ажилтан дагаж мөрдөнө.

1.3.Согтууруулах ундаа гэдэгт хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, 2 (хоёр) хувиас дээш этилийн спирт агуулсан дарс, пиво, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи, айраг зэргийг хамруулан ойлгох бөгөөд Алкотестер багажаар “Үлээлгэх” сорилыг авч, цусан дахь спиртийн агууламжийг тодорхойлж болно.

1.4.Мансууруулах бодис гэдэгт хүний уураг тархи, мэдрэл сэтгэхүйд хор нөлөө үзүүлдэг химийн болон ургамлын гаралтай бодис болон мансууруулах үйлчилгээтэй эм, бэлдмэлийг тус тус хамруулан ойлгох бөгөөд энэ төрлийн зүйлийг хэрэглэхийг Монгол Улсын хуулиар бүр мөсөн хориглогддог болно. Энэ төрлийн бодисыг хэрэглэсэн ажилтан тус хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

### Хоёр. Үүрэг

2.1.Компанийн нийт ажилтнууд болон зочид, төлөөлөгчид, гэрээт, туслан гүйцэтгэгч компанийн ажилтан ажлын байр, амрах хотхонд байрлах, тээврийн хэрэгслээр зорчих үедээ согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.

2.2.Уурхайн бүс рүү болон хотхон руу согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнийг нэвтрүүлэхгүй бөгөөд энэ бүсэд эдгээрийг хадгалах, худалдах, хэрэглэхийг хатуу хориглоно.

2.3.Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээнд тавих ерөнхий хяналтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтэс (цаашид “ХАБЭАБОХ” гэх) хэрэгжүүлнэ.

2.4.Компанийн болон гэрээт ажилтан бүр согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, эсвэл сэжигтэй тохиолдол илэрсэн даруйд Хөдөлмөрийн аюулгүйн байдал /цаашид ХАБ/-ын ажилтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

2.5.Хэрэв ажилтан болон зочин нь эмчээс олгосон жорын дагуу мансууруулах үйлчилгээ бүхий эм хэрэглэж байгаа бол жорыг биедээ авч явна. Мөн энэ төрлийн эм хэрэглэж байгаа тухай Уурхайн эмчид 24 цагийн өмнө мэдэгдсэн байна.

## Гурав. Хяналт тавих

3.1.ХАБ-ын ажилтан болон харуул хамгаалалтын ажилтан нь захиргаа, хүний нөөцийн мэргэжилтний хамт согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн сэжиг бүхий ажилтныг шалгаж<sup>1</sup>, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.1.Ажилтны согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, ажилтнаас энэ талаар асууж лавлах;

3.1.2.Ажилтны ашиглаж буй өрөө тасалгаа, ширээ, шүүгээ гэх мэт компанийн өмч хөрөнгөнд, мөн шаардлагатай тохиолдолд ажилтнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр түүний хувийн эд зүйлд согтууруулах ундаа, мансууруулах бодис бий эсэхийг шалгах;

3.1.3.Согтуулуурах ундаа хэрэглэсэн эсэхийг Монгол Улсад хэрэглэхийг эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн согтуурлын зэрэг тогтоох зориулалтын багаж болох алколайзераар “Үлээлгэх” сорил хийлгэж шалгах;

3.1.4.Ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн тохиолдолд тухайн ажилтны ажлыг зогсоож, ажлын байрнаас явуулах;

3.1.5.Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн ажилтанд хариуцлага хүлээлгэх, зохих арга хэмжээ тооцуулахаар захиргааны албан тушаалтанд хандах;

3.1.6.Согтолтын зэрэг хэт их, ухаан алдсан байгаа бол зохих эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд орон нутгийн цагдаагийн байгууллагад хүлээлгэж өгөх;

3.1.7.Компанийн ажилтнуудад согтууруулах ундаа, мансууруулах бодисын хор уршгийг ухуулан таниулах;

3.2.Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг сорил шинжилгээгүй, эсхүл сорилоор шалгах аль ч тохиолдолд дараах баримтаар баримтжуулна:

3.2.1.Шалгалт явуулахдаа баталсан маягтын дагуу тэмдэглэл хөтлөх.

3.2.2.Шалгалтын явцад 2 (хоёр) буюу түүнээс дээш гэрч<sup>2</sup>ийг байлцуулан, шалгаж дууссаны дараа тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

3.2.3.Техникийн боломж байгаа тохиолдолд дүрс болон дуу хураагуураар бичлэг хийж болно.

3.3.Дараах тохиолдолд ажилтныг согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн байна гэж шууд дүгнэж, баталсан маягтын дагуу тэмдэглэл хөтлөнө:

3.3.1.Ажилтан согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн болох нь илэрхий мэдэгдэж, хэрэглэсэн болохоо өөрөө хүлээн зөвшөөрвөл;

3.3.2.Ажилтан алкоголийн сорил, мансууруулах бодисын шинжилгээ хийлгэхээс шалтгаангүйгээр татгалзвал;

<sup>1</sup> Шалгах үйл ажиллагааг боломжтой бол камераар тоноглогдсон өрөөнд явуулах шаардлагатай.

<sup>2</sup> Захиргаа, хүний нөөцийн болон Харуул хамгаалалтын албаны ажилтан байх нь тохиромжтой.

3.4. Үлээлгэх сорил хийх багаж нь харуул хамгаалалтын ажилтан болон ХАБ-ын ажилтан хэрэглэх эрхтэй бөгөөд түүнийг энэхүү журамд заасан үлээлгэх сорил хийлгэх эрх бүхий этгээд хариуцна.

3.5. Үлээлгэх сорил хийлгэх багаж ажиллахгүй болсон, гэмтсэн тохиолдолд багажийг нэн даруй засварлуулах, эсхүл шинээр худалдан авах захиалгыг холбогдох хэлтэс, нэгжид өгнө.

### **Дөрөв. Согтуурлын зэрэг тогтоох сорил**

4.1. Цусан дахь алкоголийн хэмжээ тодорхойлох зорилгоор үлээлгэх сорилыг дор дурдсан тохиолдолд хийнэ.

4.1.1. Сайн дурын сорил. Ажилтан өөрийгээ болон бусдыг эрсдэлд оруулахаас сэргийлж сайн дурын үндсэн дээр алкоголын сорилд хамрагдаж болно.

4.1.2. Ажилтанг ээлжийн ажилд гарахын өмнө нь хугацаат сорилд хамруулна.

4.1.3. ХАБ хариуцсан нэгжийн болон харуул хамгаалалтын ажилтан эсхүл удирдах албан тушаалтан өөрийн хариуцсан нэгж хэсгийн ажилтнуудыг ажлаа эхлэхийн өмнө нь, ажил үүргээ гүйцэтгэх явцад нь түүвэрлэн сонгож гэнэтийн сорилд хамруулж болно.

4.1.4. Ажилтныг согтууруулах ундаа хэрэглэсэн талаарх мэдээлэл ирсэн, мөн согтууруулах ундаа хэрэглэсэн байж болзошгүй бусад үндэслэлтэй сэжиг, таамаглал бий болсон тохиолдолд үлээлгэх сорил хийнэ.

4.1.5. Ажлын байранд гарсан хэрэг, ослын үед түүний шалтгааныг тогтоох зорилгоор үлээлгэх сорил заавал авна.

4.1.6. Үлээлгэх сорилыг компанийн төв оффис, тээврийн зам, мөн бусад ажлын байранд тухайн ажилтныг шууд хариуцах албан тушаалтан болон түүний итгэмжилсэн албан тушаалтан дангаараа гүйцэтгэж болно.

4.1.7. Сорил эхлэхийн өмнө сонгосон хоёр гэрчээр сорилын багажийг үлээлгэж хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг шалгана.

4.2. Сорилыг эхний, давтан, батлах сорилт гэсэн дараахь байдлаар 3 шатлалтайгаар гүйцэтгэнэ.

4.2.1. Эхний үлээлгэх сорилтын үр дүн зөвшөөрөгдөх хэмжээнээс бага гарсан тохиолдолд согтууруулах ундаа хэрэглээгүйд тооцно.

4.2.2. Сорилын үр дүн нь зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан тохиолдолд сорил хийлгэгчээс сорилын үр дүнг зөвшөөрч буй эсэхийг тодруулна. Сорил хийлгэгч үр дүнг зөвшөөрсөн тохиолдолд түүнийг согтууруулах ундаа хэрэглэсэнд тооцож “Зөрчсөн тохиолдолд арга хэмжээ авах заавар”-ын дагуу ажиллана. Сорил хийлгэгч сорилын үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол давтан сорил хийнэ.

4.2.3. Давтан сорилтыг эхний сорил хийснээс хойш арван (10) минут хүлээсний дараа хийнэ.

4.2.4. Давтан сорилын үр дүн эхний сорилын үр дүнг баталвал сорил хийлгэгчийг согтууруулах ундаа хэрэглэсэнд тооцно.

4.2.5. Давтан сорилын үр дүн эхний сорилын үр дүнгээс зөрвөл батлах сорил хийнэ.

4.2.6.Эхний болон давтан сорилын үр дүн зөрвөл дахин сорил хийснээс хойш арван (10) минут хүлээсний дараа батлах сорилтыг хийнэ.

4.2.7.Батлах сорилын үр дүн зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан тохиолдолд сорил хийлгэгчийг согтууруулах ундаа хэрэглэсэнд тооцно.

4.2.8.Сорил хийлгэгч батлах сорилын үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд сорил хийх ойрхон эмнэлэг байгаа бол сүүлчийн сорил хийгдсэнээс хойш ерэн (90) минутын дотор тухайн эмнэлэгт өөрийн зардлаар цус болон шээсний шинжилгээ өгч шинжлүүлнэ. Уг шинжилгээ нь тухайн ажилтны цусан дахь спиртийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс илүүгүй байсныг баталсан тохиолдолд тухайн ажилтныг согтууруулах ундаа хэрэглээгүйд тооцож, түүний шинжилгээний зардлыг нөхөн олгоно.

4.2.9.Хэрэв ойрхон эмнэлэг байгаагүй, эсхүл эмнэлэг байсан ч сорил хийлгэгч тухайн эмнэлэгт шинжилгээ хийлгээгүй бол батлах сорилын үр дүнг үнэн зөв гэж үзэж, сорил хийлгэгчийг согтууруулах ундаа хэрэглэсэнд тооцож болно.

#### **Тав. Мансууруулах бодисын шинжилгээ**

5.1.Компанийн эсхүл гэрээт байгууллагын ажилтан мансууруулах бодис хэрэглэсэн сэжигтэй тохиолдолд хамгийн ойр байгаа эмнэлэгт ерэн (90) минутын дотор очиж цусны шинжилгээ өгүүлнэ.

5.2.Шинжилгээний хариу гартал ажилтныг ажил үүргээ гүйцэтгэхийг хориглоно. Шинжилгээний хариугаар мансууруулах бодис хэрэглэсэн болох нь тогтоогдвол “Зөрчсөн тохиолдолд арга хэмжээ авах заавар”-ын дагуу ажиллана.

#### **Зургаа. Гэрээт ажилчдад сорил хийх**

6.1.Уурхайн бүсэд ажиллаж буй нийт гэрээт ажилчдыг үлээлгэх сорил болон мансууруулах бодисын шинжилгээнд энэхүү журамд заасны дагуу хамруулж болно.

6.2.Үлээлгэх сорилын үр дүн нь зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан тохиолдолд “Зөрчсөн тохиолдолд арга хэмжээ авах заавар”-ын дагуу арга хэмжээ авч, сорил хийлгэгчийн ажлыг зогсоож, түүнийг ажлын байрнаас явуулахыг гэрээлэгчээс шаардана. Энэ шаардлагыг гэрээлэгчийн ажлын багийн ахлагч гүйцэтгэх үүрэгтэй.

#### **Долоо. Хариуцлага**

7.1.Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох холбогдох хууль, “ЭТТ” ХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.


7.2.Ажилтны гаргасан зөрчилтэй холбогдуулан уг асуудлыг цагдаагийн болон хууль хяналтын байгууллагаар шалгуулж болно.

7.3.Зөрчил гаргасан этгээд нь гэрээт компанийн ажилтан бол ажлын байрнаас явуулж, зохих арга хэмжээг авахыг гэрээт байгууллагын удирдлагаас шаардана.


--- оОо ---

## АЛКОЛАЙЗЕР БАГАЖ

Цусан дахь алкоголийн хэмжээг шинжлэх үлээх сорилыг "Алколайзер" нэртэй үлээх сорилын багажаар явуулна. Уг багаж нь "NO ALCOHOL / ALCOHOL" заалт бүхий багаж бөгөөд тусгай зориулалтын нэмэлт гуурсаар цусан дахь спиртийн хэмжээг тодорхойлдог багаж юм. (Зураг 1, 2, 3)



Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.

## СОГТУУРЛЫН ЗЭРЭГ ТОГТООХ СОРИЛ ХИЙСЭН ТУХАЙ БҮРТГЭЛ

*Согтуурлын зэрэг тогтоох сорилын хариу эерэг гарсан тохиолдолд энэхүү маягтыг бөглөнө.  
ETT-OHS-CP03-A1 - Согтууруулах ундаа, мансууруулах бодисын журмын хавсралт*

Огноо/Цаг:

Зөрчил  
№:

/2015

Байршил:

Хариуцсан  
хэлтэс/Компани:

Шалгасан ажилтны  
нэр:

Гарын  
үсэг:

### Зөрчил гаргасан хүний мэдээлэл:

Овог, Нэр:	Албан тушаал:	
I - Сорил. Үр дүн - 1:	II - Сорил. Үр дүн - 2:	III - Сорил. Үр дүн - 3:
Үр дүнг зөвшөөрөв Гарын үсэг:	РД:	Огноо:

*Сорил хийснээс хойш 90 минутын дотор мэргэжлийн эмнэлэгт шинжилгээ өгөөгүй тохиолдолд одоогийн сорилын үр дүнг үнэн зөв гэж үзэхийг сануулав.*

*Тухайн хүн согтуурлын зэрэг тогтоох сорил хийлгэхээс татгалзсан тохиолдолд шалгагч уг хүнийг сорилд унасанд тооцож доор тэмдэглэн бүх гэрчийн этгээдүүдээр гарын үсэг зуруулан баталгаажуулна.*

Татгалзсан тухай  
тайлбар:

Авсан арга  
хэмжээ:

### Гэрчилсэн<sup>3</sup> хүмүүсийн мэдээлэл:

<sup>3</sup> Тухайн зөрчил гаргасан хүнд согтуурлын зэрэг тогтоох сорил хийх үед хамт байлцсан хүмүүс орно.



## СОГТУУРЛЫН ЗЭРЭГ ТОГТООХ СОРИЛ ХИЙСЭН ТУХАЙ БҮРТГЭЛ

Согтуурлын зэрэг тогтоох сорилын хариу эерэг гарсан тохиолдолд энэхүү маягтыг бөглөнө.  
ETT-OHS-CP03-A1 - Согтууруулах ундаа, мансууруулах бодисын журмын хавсралт

“Эрчим” ХХА-  
ны ажилтан:

Гарын үсэг:

Захиргаа, ХН-  
ийн  
мэргэжилтэн:

Гарын үсэг:

:

Гарын үсэг:

:

Гарын үсэг:

Согтуурлын зэрэг тогтоох сорилын хариу эерэг гарсан тохиолдолд энэхүү зааврыг дагаж мөрдөнө..  
ETT-OHS-CF03-A1 - Согтууруулах ундаа, мансууруулах бодисын журмын хавсралт

1. Үлээлгэх сорил хийгч нь сорил хийлгэгчээс **“Та сүүлийн 20 минутын дотор ямар нэг хоол, ундаа болон эм хэрэглэсэн үү”** хэмээн асууж **“тийм”** гэж хариулсан бол дахин арван (10) минут хүлээсний дараа сорил хийнэ.
2. Үлээлгэх давтан сорилыг хийхээс өмнө доод тал нь арван (10) минут хүлээнэ.
3. Үлээлгэх сорил хийгч нь сорил хийлгэгчид **“Дараагийн сорил хийхээс өмнө шингэн зүйл уухгүй, тамхины төрлийн бүтээгдэхүүн хэрэглэх буюу татаж болохгүй”** болохыг сануулж, түүнд хяналт тавина.
4. Давтан үлээлгэх сорилын үр дүн нь зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байвал тухайн ажилтнаар тэмдэглэлд гарын үсэг зуруулж ажлын байрандаа очин ажлаа үргэлжлүүлэхийг зөвшөөрнө. Ийнхүү зөвшөөрсөн тухай тэмдэглэлд тусгана.
5. Давтан үлээлгэх сорилын үр дүн зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан бол сорил хийлгэгчид **“Та үлээх сорилд хоёр удаа уналаа. Таны цусан дахь спиртийн хэмжээ зөвшөөрөгдөх түвшнээс өндөр байна. Таны ажил олгогч таныг төслийн газраас тээвэрлэх унааны асуудлыг зохицуулна”** гэж хэлнэ.
6. Хэрэв ажилтан батлах сорил хийлгэхийг хүсч, хийлгэсний дараа батлах сорилын үр дүнг зөвшөөрөхгүй тохиолдолд тэмдэглэлд энэ тухай тусгаж, ерэн (90) минутын дотор ойр орших эмнэлэгт шинжилгээ өгөхийг, хэрэв өгөхгүй бол, эсхүл тийм эмнэлэг байхгүй бол сорилын үр дүнг үнэн зөв гэж үзэх тухай тайлбарлан өгч тэмдэглэлд гарын үсэг зуруулна.
7. Мансууруулах бодисын шинжилгээний үр дүн **“эерэг буюу хэрэглэсэн”** гэж гарвал сорил хийсэн этгээд нь сорил хийлгэгчид **“Шинжилгээгээр Та мансууруулах бодис хэрэглэсэн нь тогтоогдлоо. Таны ажил олгогч таныг төслийн газраас тээвэрлэх унааны асуудлыг зохицуулна”** гэж хэлнэ.
8. Сорил хийлгэгч нь гэрээт компанийн ажилтан бол түүнийг ажлын байранд ажил үүрэг гүйцэтгэхийг хориглож, тухайн компанийн удирдлагад арга хэмжээ авахыг даалгана.

Ажилтан үлээлгэх сорил хийлгэхээс татгалзвал **“Та нэгэнт үлээлгэх сорил хийлгэхээс татгалзсан болохоор манай журмын дагуу Таныг согтууруулах ундаа хэрэглэсэн гэж үзнэ. Хэдий тийм боловч Та 90 минутын дотор өөрийн зардлаар цус, шээсний шинжилгээ өгч, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ тогтоолгох бүрэн эрхтэй”** гэж хэлэн тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

Ажилтан мансууруулах бодисын шинжилгээ хийлгэхээс татгалзвал **“Та нэгэнт мансууруулах бодисын шинжилгээ хийлгэхээс татгалзсан болохоор манай журмын дагуу Таныг мансууруулах бодис хэрэглэсэн гэж үзнэ”** гэж хэлэн тэмдэглэлд гарын үсэг зуруулна.